

УВС АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Увс аймгийн Зүүнхангай сумын Ерөнхий боловсролын 2025 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Аудитын код: УВА-2026/050/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас: www.audit.mn

Улаангом хот

2026 он

Увс аймаг дахь Төрийн аудитын газар,

Дарга, тэргүүлэх аудитор: М.Батсуурь

Утас: 70453317, Цахим хаяг: BatsuuriM@audit.gov.mn

Аудитын менежер: М.Бат-Амгалан

Утас: 70453799, Цахим хаяг: Bat-Amgalanm@audit.gov.mn

Аудитор: Р.Аюуш

Утас: 70453799, Цахим хаяг: Ayushr@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

АГУУЛГА

1. Хараат бус аудиторын дүгнэлт.....	3
2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл.....	5
3. Санхүүгийн тайлангийн тодруулга.....	12
3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа.....	12
3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин.....	13
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал.....	13
3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлт.....	13
3.5 Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд.....	14
4. Аудитын тайлан.....	15
4.1 Ерөнхий зүйл	15
4.2 Материаллаг байдал	16
4.3 Төрийн хэмнэлтийн хуулийн хэрэгжилт.....	16
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	16
4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	17
4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал	17
5. Аудитын илрүүлэлт	17

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт



**УВС АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

213400, Увс аймаг, Улаангом сум,
Ө.Бадрахын гудамж
Утас: 70-45-33-17, Факс: (976)70-45-33-17,
E-mail: uvs@audit.gov.mn

ЗҮҮНХАНГАЙ СУМЫН ЕРӨНХИЙ
БОЛОВСРОЛЫН СУРГУУЛИЙН
ЗАХИРАЛ Ц.БААСАНДОРЖ ТАНАА

2026.02.24 № УВА-2026/050/НА-СТА-ТЦЗ
танай _____-ны № _____-т

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-т заасны дагуу Зүүнхангай сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бидний дүгнэлтээр Зүүнхангай сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал болон тайлант жилийн эцсээрх санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, төсвийн гүйцэтгэлийг бүх материаллаг талаар нь Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв илэрхийлсэн байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

АДБОУС 2706.7-д тодорхойлсноор асуудлыг онцолсон хэсэгт санхүүгийн тайлангийн тухай хэрэглэгчдийн ойлголтыг бүрдүүлэхэд ач холбогдолтой санхүүгийн тайланд толилуулсан, тодруулсан мэдээлэл байхгүй болно.

Аудитын гол асуудал

АДБОУС 2701.8-д тодорхойлсон тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад үлэмж нөлөө үзүүлэх ажил гүйлгээ байхгүй болно.

Бусад асуудлын хэсэг

Санхүүгийн тайлангийн тодруулга толилуулгад тусгаагүй, аудитын хамрах хүрээний хязгаарлалтын улмаас аудитын хангалттай, зохистой нотолгоог олж авах боломжгүй асуудал гараагүй болно.

8525050244

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБООУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



М.БАТСУУРЬ

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	329,442,217.34	296,534,412.53
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	234,346,847.71	209,994,529.80
312	Банкинд байгаа бэлэн мөнгө	234,346,847.71	209,994,529.80
3121	Төгрөг	234,346,847.71	209,994,529.80
31211	Төрийн сангийн харилцах	234,346,847.71	209,994,529.80
35	БАРАА МАТЕРИАЛ	95,095,369.63	86,539,882.73
351	Түүхий эд материал	89,500.00	33,350.00
35130	Эм боох материал	89,500.00	33,350.00
354	Хангамжийн материал	95,005,869.63	86,506,532.73
35410	Бичиг хэргийн материал	638,000.00	451,000.00
35420	Аж ахуйн материал	65,377,159.62	56,302,332.72
35440	Түлш, шатах тослох материал	00.01	00.01
35460	Хүнсний материал	28,990,710.00	29,753,200.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	2,602,393,493.20	2,594,092,011.51
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	2,602,393,493.20	2,594,092,011.51
392	Биет хөрөнгө	2,498,943,493.20	2,490,672,011.51
39201	Барилга, байгууламж, орон сууц	2,292,293,198.76	2,288,484,412.41
39202	Хуримтлагдсан элэгдэл	-193,887,523.95	-228,908,516.64
39203	Авто-тээврийн хэрэгсэл	28,500,000.00	32,500,000.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	-28,500,000.00	-28,500,000.00
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	419,795,525.66	442,341,105.33
39206	Хуримтлагдсан элэгдэл	-182,416,788.72	-179,021,994.75
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	181,188,347.53	182,323,510.35
39208	Хуримтлагдсан элэгдэл	-61,152,180.65	-60,237,216.13
39214	Бусад үндсэн хөрөнгө	37,846,075.84	30,422,364.14
39215	Хуримтлагдсан элэгдэл	-30,203,739.91	-24,212,231.84
39217	Ном	35,480,578.64	35,480,578.64
393	Биет бус хөрөнгө	103,450,000.00	103,420,000.00
39301	Программ хангамж	2,740,000.00	2,740,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	-2,560,000.00	-2,590,000.00
39303	Бусад биет бус хөрөнгө	103,270,000.00	103,270,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	2,931,835,710.54	2,890,626,424.04
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	15,029,600.00	57,123,064.02
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	15,029,600.00	57,123,064.02
413	Өглөг	15,029,600.00	57,123,064.02
41310	Ажилчидтай холбогдсон өглөг	00.00	247,935.67
4136	Бусад өглөг	15,029,600.00	56,875,128.35
41361	Байгууллагад төлөх өглөг	15,029,600.00	56,875,128.35
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	2,916,806,110.54	2,833,503,360.02
51	Засгийн газрын хувь оролцоо	2,916,806,110.54	2,833,503,360.02
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	418,331,714.20	418,331,714.20
51101	Өмч: - төрийн	418,331,714.20	418,331,714.20
512	Хуримтлагдсан үр дүн	1,126,360,586.70	1,048,536,994.53
51210	Өмнөх үеийн үр дүн	1,126,360,586.70	1,131,839,745.05
51220	Тайлант үеийн үр дүн	00.00	-83,302,750.52
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	1,372,113,809.64	1,366,634,651.29
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	2,931,835,710.54	2,890,626,424.04



2.2. Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	2,276,947,503.30	2,492,462,233.10
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	194,627,203.30	138,025,333.10
120	Нийтлэг татварын бус орлого	194,627,203.30	138,025,333.10
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	4,052,800.00	104,559,604.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	852,800.00	339,800.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	3,200,000.00	43,403,000.00
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	00.00	60,816,804.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	2,082,320,300.00	2,354,436,900.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	1,824,721,700.00	2,136,250,600.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	1,824,721,700.00	2,136,250,600.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	257,598,600.00	218,186,300.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	257,598,600.00	218,186,300.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	2,021,352,853.09	2,572,074,099.80
21	УРСГАЛ ЗАРДАЛ	2,021,352,853.09	2,572,074,099.80
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,947,330,569.75	2,484,751,099.80
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,311,778,315.72	1,680,118,101.31
210101	Үндсэн цалин	832,665,578.32	983,164,196.44
210102	Нэмэгдэл	409,130,202.40	548,263,908.87
210103	Унаа хоолны хөнгөлөлт	00.00	49,865,000.00
210104	Урамшуулал	69,982,535.00	98,824,996.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	164,097,208.41	209,475,857.37
210201	Тэтгэврийн даатгал	112,640,221.76	143,408,880.68
210202	Тэтгэмжийн даатгал	13,251,790.91	16,937,022.59
210203	ҮОМШӨ-ний даатгал	6,835,437.20	8,876,904.83
210204	Ажилгүйдлийн даатгал	6,273,950.52	8,050,609.39
210205	Эрүүл мэндийн даатгал	25,095,808.02	32,202,439.88
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	253,057,466.66	322,858,032.15
210301	Гэрэл, цахилгаан	9,367,699.66	9,223,626.65
210302	Түлш, халаалт	243,359,767.00	313,634,405.50
210303	Цэвэр, бохир ус	330,000.00	00.00
2104	Хангамж, бараа материалын зардал	28,519,648.00	39,056,123.00
210401	Бичиг хэрэг	1,808,000.00	2,627,400.00
210402	Тээвэр, шатахуун	11,851,048.00	10,900,223.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	14,860,600.00	25,528,500.00
2105	Нормативт зардал	59,261,228.00	67,096,260.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	136,628.00	215,950.00
210502	Хоол, хүнс	59,124,600.00	66,880,310.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	3,000,000.00	4,891,000.00
210604	Урсгал засвар	3,000,000.00	4,891,000.00
2107	Томилолт, зочны зардал	00.00	80,000.00
210702	Дотоод албан томилолт	00.00	80,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	25,975,049.37	24,827,249.10
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	852,800.00	00.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	25,122,249.37	24,827,249.10
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	101,641,653.59	136,348,476.87
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	10,346,368.00	15,660,123.00




210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	14,417,900.00	27,948,081.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	76,877,385.59	92,740,272.87
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	74,022,283.34	87,323,000.00
2131	Засгийн газрын урсгал шилжүүлэг	1,541,133.34	500.00
213102	Засгийн газрын гадаад шилжүүлэг	1,541,133.34	500.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	72,481,150.00	87,322,500.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	55,456,750.00	87,322,500.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	17,024,400.00	00.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	255,594,650.21	-79,611,866.70
225	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	00.00	3,690,883.82
225001	Үндсэн хөрөнгө худалдсаны гарз	00.00	3,690,883.82
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)	00.00	-3,690,883.82
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	255,594,650.21	-83,302,750.52

2.3. Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	2,086,373,100.00	2,398,179,700.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	4,052,800.00	43,742,800.00
120	Нийтлэг татварын бус орлого	4,052,800.00	43,742,800.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	4,052,800.00	43,742,800.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	852,800.00	339,800.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	3,200,000.00	43,403,000.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	2,082,320,300.00	2,354,436,900.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	1,824,721,700.00	2,136,250,600.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	1,824,721,700.00	2,136,250,600.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	257,598,600.00	218,186,300.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	257,598,600.00	218,186,300.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	1,952,091,314.50	2,352,907,717.91
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,952,091,314.50	2,352,907,717.91
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,878,069,031.16	2,273,197,417.91
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,311,778,536.71	1,678,937,041.21
210101	Үндсэн цалин	833,439,861.67	985,114,594.75
210102	Нэмэгдэл	411,238,820.46	545,668,767.84
210103	Унаа хоолны хөнгөлөлт	00.00	49,194,488.24
210104	Урамшуулал	67,099,854.58	98,959,190.38
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	164,096,987.42	210,408,981.80
210201	Тэтгэврийн даатгал	112,640,221.76	143,750,340.56
210202	Тэтгэмжийн даатгал	13,251,770.91	16,911,710.53
210203	ҮОМШӨ-ний даатгал	6,835,237.20	8,713,233.69
210204	Ажилгүйдлийн даатгал	6,273,949.53	8,208,043.38
210205	Эрүүл мэндийн даатгал	25,095,808.02	32,825,653.64
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	253,057,466.66	213,330,800.00
210301	Гэрэл, цахилгаан	9,367,699.66	9,266,903.85
210302	Түлш, халаалт	243,359,767.00	204,063,896.15
210303	Цэвэр, бохир ус	330,000.00	00.00
2105	Нормативт зардал	66,656,880.00	67,642,800.00
210502	Хоол, хүнс	66,656,880.00	67,642,800.00



2106	Эд хогшил, урсгал засварын зардал	3,000,000.00	4,855,000.00
210604	Урсгал засвар	3,000,000.00	4,855,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	24,204,049.37	27,615,271.90
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	852,800.00	339,800.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	23,351,249.37	27,275,471.90
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	55,275,111.00	70,407,523.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	40,857,211.00	60,682,223.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	14,417,900.00	9,725,300.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	74,022,283.34	79,710,300.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	72,481,150.00	79,709,800.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	55,456,750.00	79,709,800.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	17,024,400.00	00.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	1,541,133.34	500.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	134,281,785.50	45,271,982.09
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	28,948,300.00	69,624,300.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	28,948,300.00	69,624,300.00
2200	Дотоод эх үүсвэрээр	28,948,300.00	69,624,300.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	28,948,300.00	69,624,300.00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	-28,948,300.00	-69,624,300.00
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	105,333,485.50	-24,352,317.91
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	129,013,362.21	234,346,847.71
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	234,346,847.71	209,994,529.80

2.4. Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Бусад	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
C01	2024 оны 01-р сарын 01-нээрх үлдэгдэл	418,331,714.20	1,372,113,809.64	731,210,409.34	00.00	2,521,655,933.18
C02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	00.00	00.00	00.00	00.00	00.00
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	418,331,714.20	1,372,113,809.64	731,210,409.34	00.00	2,521,655,933.18
C04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт	00.00	00.00	00.00	00.00	00.00
C05	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт	00.00	00.00	00.00	00.00	00.00
C06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	00.00	00.00	00.00	00.00	00.00
C07	Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	139,555,527.15	00.00	139,555,527.15
C08	2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	418,331,714.20	1,372,113,809.64	1,126,360,586.70	00.00	2,916,806,110.54
D01	2025 оны 01-р сарын 01-нээрх үлдэгдэл	418,331,714.20	1,372,113,809.64	1,126,360,586.70	00.00	2,916,806,110.54
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	00.00	00.00	5,479,158.35	00.00	5,479,158.35



D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	418,331,714.20	1,372,113,809.64	1,131,839,745.05	00.00	2,922,285,268.89
D04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	00.00	-5,479,158.35	00.00	00.00	-5,479,158.35
D05	Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт	00.00	00.00	00.00	00.00	00.00
D06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	00.00	00.00	00.00	00.00	00.00
D07	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү	00.00	00.00	00.00	00.00	00.00
D08	Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	-83,302,750.52	00.00	-83,302,750.52
D09	2025 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	418,331,714.20	1,366,634,651.29	1,048,536,994.53	00.00	2,833,503,360.02

2.5. Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

/төгрөгөөр/

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны			
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл				
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	2,438,154,100.00	2,204,345,717.91	233,808,382.09	90.4%
21	УРСГАЛ ЗАРДАЛ	2,438,154,100.00	2,204,345,717.91	233,808,382.09	90.4%
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	2,358,103,000.00	2,124,635,917.91	233,467,082.09	90.1%
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,867,483,300.00	1,678,937,041.21	188,546,258.79	89.9%
210101	Үндсэн цалин	1,137,380,000.00	985,114,594.75	152,265,405.25	86.6%
210102	Нэмэгдэл	654,569,700.00	545,668,767.84	108,900,932.16	83.4%
210103	Унаа хоолны хөнгөлөлт	00.00	49,194,488.24	-49,194,488.24	
210104	Урамшуулал	75,533,600.00	98,959,190.38	-23,425,590.38	131.0%
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	233,435,600.00	210,408,981.80	23,026,618.20	90.1%
210201	Тэтгэврийн даатгал	158,736,100.00	143,750,340.56	14,985,759.44	90.6%
210202	Тэтгэмжийн даатгал	18,674,800.00	16,911,710.53	1,763,089.47	90.6%
210203	ҮОМШӨ-ний даатгал	9,337,500.00	8,713,233.69	624,266.31	93.3%
210204	Ажилгүйдлийн даатгал	9,337,500.00	8,208,043.38	1,129,456.62	87.9%
210205	Эрүүл мэндийн даатгал	37,349,700.00	32,825,653.64	4,524,046.36	87.9%
2105	Нормативт зардал	67,647,600.00	67,642,800.00	4,800.00	100.0%
210502	Хоол, хүнс	67,647,600.00	67,642,800.00	4,800.00	100.0%
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	28,994,200.00	27,615,271.90	1,378,928.10	95.2%
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	339,800.00	339,800.00	0.00	100.0%
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	28,654,400.00	27,275,471.90	1,378,928.10	95.2%
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	160542300.00	140031823.00	20,510,477.00	87.2%
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	150,662,800.00	130,306,523.00	20,356,277.00	86.5%
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	9,879,500.00	9,725,300.00	154,200.00	98.4%
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	80051100.00	79709800.00	341,300.00	99.6%
2132	Бусад урсгал шилжүүлэг	80,051,100.00	79,709,800.00	341,300.00	99.6%
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	80,051,100.00	79,709,800.00	341,300.00	99.6%
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	2,190,920,300.00	2,179,993,400.00	258,160,700.00	89.4%
1310	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	2,150,120,500.00	2,136,250,600.00	13,869,900.00	99.4%
131001	Улсын төсвөөс санхүүжих	2,150,120,500.00	2,136,250,600.00	13,869,900.00	99.4%

120004	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	54,669,800.00	43,742,800.00	10,927,000.00	15.2%
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	339,800.00	339,800.00	0.00	100.0%
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	54,330,000.00	43,403,000.00	10,927,000.00	79.9%
1200043	Урьд оны үлдэгдлээс санхүүжих	233,363,800.00		233,363,800.00	
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	00.00	234,346,847.71	234,346,847.71	-
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	00.00	209,994,529.80	209,994,529.80	-
62	АЖИЛЛАГСДЫН ТОО	58.00	55.00	3.00	100.0%
620001	Удирдах ажилтан	01.00	01.00	0.00	100.0%
620002	Гүйцэтгэх ажилтан	41.00	38.00	3.00	100.0%
620003	Үйлчлэх ажилтан	16.00	16.00	0.00	100.0%

2.6 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан /Орон нутгийн төсөв/

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл				
I	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	218,186,300.00	218,186,800.00	(500.00)	100.0%
21	УРСГАЛ ЗАРДАЛ	218,186,300.00	218,186,800.00	(500.00)	100.0%
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	218,186,300.00	218,186,800.00	(500.00)	100.0%
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	213,330,800.00	213,330,800.00	-	100.0%
210301	Гэрэл, цахилгаан	18,739,600.00	9,266,903.85	9,472,696.15	49.5%
210302	Түлш, халаалт	190,408,500.00	204,063,896.15	(13,655,396.15)	107.2%
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	4,855,500.00	4,855,000.00	500.00	100.0%
210604	Урсгал засвар	4,855,500.00	4,855,000.00	500.00	100.0%
II	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	218,186,300.00	218,185,800.00	500.00	100.0%
	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	218,186,300.00	218,185,800.00	500.00	100.0%
132001	Орон нутгийн төсвөөс	218,186,300.00	218,185,800.00	500.00	100.0%

3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Зүүнхангай сумын Ерөнхий боловсролын сургууль нь боловсролын салбарын бодлого, хууль тогтоомжийн хүрээнд бага дунд боловсролын сургалтын хөтөлбөр, төлөвлөгөөг хэрэгжүүлэх, багшийн тасралтгүй хөгжлийг дэмжих ажлыг мэргэжлийн болон захиргааны удирдлагаар ханган ажиллаж, 2025-2026 оны хичээлийн жилд “Багшийн мэргэжлийн тасралтгүй хөгжлийг дэмжиж, сурагчдыг бие даан сурах арга барилд сургаж, чадваржуулахад хамтын ажиллагааг чиглүүлнэ” зорилгын дор 6 зорилт дэвшүүлэн сургалт хүмүүжлийн үйл ажиллагааг явуулж байна.

3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин



Байгууллагын үйл ажиллагаа явуулж буй хууль эрх зүйн орчны талаар болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын Нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын хүрээнд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагааг явуулж байна. Үүнд:

- Төсвийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль
- Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль
- Боловсролын тухай хууль
- Шилэн дансны тухай хууль

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд дараах өөрчлөлтүүд орсон байна. Үүнд:

- ✓ Хөдөлмөр, нийгмийн түншлэлийн гурван талт үндэсний хорооны 2024 оны 10 дугаар сарын 7-ны өдрийн 3 дугаар тогтоолоор улсын хэмжээнд мөрдөх хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 2025 оны 04 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн сард 792.0 мянган төгрөгөөр шинэчлэн тогтоосон.
- ✓ Засгийн газрын 2024 оны 12 дугаар сарын 25-ны өдрийн 238 дугаар тогтоолоор Төрийн албаны зарим албан тушаалын цалингийн хэмжээ, доод хэмжээг шинэчлэн тогтоосон.
- ✓ Сангийн сайдын 2025 оны 01 дүгээр сарын 05-ны өдрийн А/3 дугаар тогтоолоор батлагдсан "Төсвийн байгууллагын дагаж мөрдөх нягтлан бодох бүртгэлийн журам"
- ✓ Төрийн хэмнэлтийн тухай хуульд - 2022 оны 11 дүгээр сарын 11-ний өдөр, 2024 оны 06 дугаар сарын 16-ны өдөр, 07 дугаар сарын 07-ны өдөр, 2024 оны 12 дугаар сарын 12-ны өдөр,

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Зүүнхангай сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2025 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Зүүнхангай сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2025 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2025 оны А/03 дугаар тушаалаар баталсан "Төсөвт байгууллагад дагаж мөрдөх нягтлан бодох бүртгэлийн журам"-ын дагуу бэлтгэсэн байна.



Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 41,209.3 мянган төгрөгөөр буюу 1.4 хувиар буурсан байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

Үзүүлэлт	/мянган төгрөгөөр/		
	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	234,346.8	209,994.5	(24,352.3)
Бараа материал	95,095.4	86,539.9	(8,555.5)
Үндсэн хөрөнгө	2,602,393.5	2,594,092.0	(8,301.5)
Нийт хөрөнгө	2,931,835.7	2,890,626.4	(41,209.3)
Өр төлбөр	15,029.6	57,123.1	42,093.5
Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/	2,916,806.1	2,833,503.4	(83,302.8)
Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн	2,931,835.7	2,890,626.4	(41,209.3)

Төрийн сан дахь харилцах дансны үлдэгдэл нь 2024 онд 234,346.8 мянган төгрөг байсан бол 2025 онд 209,994.5 мянган төгрөг болж буурсан байна.

Авлага данс тайлант оны эхэн болон эцэст үлдэгдэлгүй байна.

Бараа материалын дансны үлдэгдэл 86,539.9 мянган төгрөг болж 8,555.5 мянган төгрөгөөр буурсан нь аж ахуйн материалын зарцуулалт голлох нөлөө үзүүлсэн байна.

Үндсэн хөрөнгийн данс нь 2,594,092.0 мянган төгрөг болж 8,301.5 мянган төгрөгөөр буурсан нь төсвийн хөрөнгөөр 69,624.3 мянган төгрөгийн хөрөнгө худалдан авч, 18,505.4 мянган төгрөгийн хөрөнгө үнэ төлбөргүй хүлээн авч, тайлант онд 92,740.3 мянган төгрөгийн үндсэн хөрөнгийн элэгдлийн зардал тооцож, 71,681.4 мянган төгрөгийн хөрөнгө акталсантай холбоотой байна.

Өр төлбөр дансны үлдэгдэл 57,123.1 мянган төгрөг болж өссөн нь 49,262.4 мянган төгрөгийн түлш халаалтын өр төлбөр, 247.9 мянган төгрөгийн ажилчидтай холбогдсон өр төлбөр байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 2,833,503.4 мянган төгрөг болж 83,302.8 мянган төгрөгөөр буурсан нь тайлант үеийн үр дүнгээс шалтгаалсан байна.

3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.


3.5.1 Төсвийн төлөвлөлт

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн санхүүжүүлэх эх үүсвэрийг улсын төсвөөс 3,264,607.1 мянган төгрөгөөр, орон нутгийн төсвөөс 284,319.6 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн захирагчийн хүргүүлсэн төсвийн төслийг 1,278,528.4 мянган төгрөгөөр бууруулж, улсын төсвөөс 2,052,212.0 мянга, орон нутгийн төсвөөс 218,186.3 мянган төгрөгөөр баталсан байна.

3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант оны батлагдсан төсвийг 385,942.1 мянган төгрөгөөр нэмэгдүүлэн тодотгосон байна. Төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 15 арга хэмжээг санхүүжүүлэхээр улсын төсвөөс 2,150,120.5 мянга, үндсэн үйл ажиллагааны орлогоос 339.8 мянга, туслах үйл



ажиллагааны орлогоос 54,330.0 мянга, урьд оны үлдэгдлээс 233,363.8 мянган нийт 2,438,154.1 мянган төгрөгийн санхүүжилт бүрдүүлэхээр байна.

Гүйцэтгэлээр улсын төсвөөс 2,136,250.6 мянга, төсөвт байгууллагын үйл ажиллагааны орлогоос 43,742.8 мянга, нийт 2,179,993.4 мянган төгрөгийн орлого төвлөрүүлж, улсын төсвөөс 13,869.9 мянган төгрөгийн дутуу санхүүжилт олгосон байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 2,204,345.7 мянган төгрөг буюу 90.4 хувьтай байна. Мөнгөн хөрөнгийн дансны эхний үлдэгдлээс 24,352.3 мянган төгрөгийг зарцуулсан байна.

Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл

/мянган төгрөгөөр/

№	Хөтөлбөр, арга хэмжээ	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Биелэлт
1	Байр ашиглалтын үйлчилгээ /80226/	2,999.6	2,998.8	0.8	100.0%
2	Хүүхэд хамгаалал /80233/	2,934.6	2,785.0	149.6	94.9%
3	Сургалт семинар /80312/	2,556.7	653.9	1,902.8	25.6%
4	Эрүүл мэндийг дэмжих /81605/	2,959.8	2,959.0	0.8	100.0%
5	Үдийн цай хөтөлбөр	80,051.1	79,709.8	341.3	99.6%
6	Дотуур байрны үйлчилгээ /81806/	300,970.8	248,637.0	52,333.8	82.6%
7	Хүүхдэд ээлтэй сургалтын орчин /81816/	42,752.0	42,540.4	211.6	99.5%
8	Боловсролын байгууллагын багш, ажилтны мэргэжил дээшлүүлэх/81823/	13,342.7	6,331.0	7,011.7	47.7%
9	Бичиг үсгийн боловсролын хөтөлбөр /81827/	23,350.3	16,039.0	7,311.3	68.7%
10	Боловсролын стандарт, сургалтын хэвийн үйл ажиллагаа /81834/	1,817,310.7	1,667,486.3	149,824.4	91.8%
11	Сургалтын хэвийн үйл ажиллагаа /81835/	80,833.4	78,491.7	2,341.7	97.1%
12	Туслах үйл ажиллагааны орлогоос /81844/	6,184.0	6,181.3	2.7	100.0%
13	Сурах бичгийн түрээс /81848/	339.8	339.8	-	100.0%
14	Сургуулийн нэмэлт хөтөлбөр хэрэгжүүлэх /81875/	10,538.6	9,196.3	1,342.3	87.3%
15	Нэмэлт- Дээд шатны төсвөөс хуваарилсан /83603/	51,030.0	39,996.4	11,033.6	78.4%
Нийт дүн		2,438,154.1	2,204,345.7	233,808.4	

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5, 2.6-д харуулав.

Аудитын ерөнхий чиглэлийн судалгааны дүн

Программын судалгааг хүснэгтээр харуулахад дараах байдалтай байна.

/мянган төгрөгөөр/

Д/Д	Программ, лиценз нийлүүлсэн байгууллагын нэр	Санхүүгийн тайланд бүртгэлтэй эсэх /тийм, үгүй/	Зориулалт	Тайланд онд гэрээний дагуу төлсөн төлбөр
1	Санхүүгийн тооцоолох групп	тийм	Санхүү	473.0



2	Дижитал ЭДҮ менежмент	үгүй	Сургалт	3,224.8
3	Ай И Ди Си	үгүй	Сургалт	5,626.5
4	ЕСМ их нүүдэл	үгүй	сургалт	2,209.7
5	Динамик мэдээний систем	үгүй	Санхүү	160.0
Нийт дүн				11,694.0

Унаа, хоол, сургалт семинарын орон тооны судалгааг хүснэгтээр харуулбал:

/мянган төгрөг/

№	Үзүүлэлт	Төсөвлөсөн	Гүйцэтгэл	Зөрүү	Тайлбар
1	Унаа, хоолны зардал	0.00	49,865.0	-49,865.0	Боловсролын сайдын 2025 оны 02 дугаар сарын 11-ний өдрийн 1/554 дүгээр албан бичгийн дагуу хоолны зардлыг 5000 төгрөгөөр тооцоон олгож эхэлсэн.
2	Сургалт, семинар, хурал, зөвлөгөөний зардал	12,615.6	12,615.6	0.00	Гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусадсаны дагуу багшийн хөгжлийн зардал, сургалт семинарын зардлаас давхардсан тоогоор 46 багш, сурагчдыг сургалтад хамруулсан байна.
3	Гадаад томилолт, арга хэмжээ	0.00	0.00	0.00	Гадаад томилолт, арга хэмжээ зардал гараагүй байна.
4	Төрд учирсан хохирлыг барагдуулахтай холбоотой зардал	0.00	0.00	0.00	Төрд учирсан хохирлыг барагдуулахтай холбоотой зардал гараагүй байна.
5	Орон тоо	58	55	3.00	Бүтэц орон тоонд байхгүй жолоочийг хавсран ажиллуулсан байна.
7	Хэвлэл мэдээлэл	0.00	0.00	0.00	Хэвлэл мэдээлэлтэй холбоотой зардал гараагүй байна.

3.5.3 Нэмэлт төсөв /Орон нутаг/

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.


Орон нутгаас байр ашиглалттай холбоотой тогтмол зардалд 213,330.8 мянган төгрөг, урсгал засварын зардалд 4,855.5 мянган төгрөгийг төсөвлөн гүйцэтгэлээр 218,185.8 мянган төгрөгийг зарцуулж, 0.5 мянган төгрөгийн буцаан төвлөрүүлсэн байна.

3.5.4 Төсөл хөтөлбөрийн үе шат, хүрэх үр дүн

Тайлант онд хэрэгжүүлсэн төсөл хөтөлбөр байхгүй байна.

3.5.5 Худалдан авах ажиллагааны гүйцэтгэл

Зүүнхангай сумын Ерөнхий боловсролын сургууль нь 102,711.2 мянган төгрөгийн төсөвт өртөгтэй үдийн цайны хүнсний материал худалдан авах тендер худалдан авах



ажиллагааг цахим хэлбэрээр нээлттэй тендер шалгаруулалтын аргаар зохион байгуулсан байна.

Харин 91,809.9 мянган төгрөгийн дотуур байрны хоол, хүнсний материалыг худалдан авахдаа шууд худалдан авалт хийсэн зөрчил илэрсэнд албан шаардлага өглөө.

4. АУДИТЫН ТАЙЛАН

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана” гэж заасны дагуу Зүүнхангай сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитыг Увс аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор Р.Аюуш гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер М.Бат-Амгалан, дарга, тэргүүлэх аудитор М.Батсуурь нар тус тус хэрэгжүүлсэн.

Зүүнхангай сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Увс аймаг дахь Төрийн аудитын газарт 2026 оны 01 дүгээр сарын 12-ны өдрийн 05 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл дунд гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2024 оны үр дүнгийн тайлангийн нийт зардлын 2,021,352.9 мянган төгрөгийн 1 хувиар буюу 20,213.5 мянган төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагатай гэж үзсэн

Гүйцэтгэлийн шатанд материаллаг байдлыг 2025 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардал 2,570,074.1 мянган төгрөгийн 1 хувиар буюу 25,720.7 мянган төгрөгөөс 80 хувиар тооцож 20,576.6 мянган төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагатай гэж үзсэн.

4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Төрийн хэмнэлтийн тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбоотойгоор Зүүнхангай сумын Ерөнхий боловсролын сургуулийн төсөв захирагчийн тухайн хуульд хамаарах зүйл заалтын хүрээнд горим сорил хэрэгжүүлсэн. Төрийн хэмнэлтийн тухай хуулийг хэрэгжүүлэн ажилласан байна.

4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.



Төрийн аудитын байгууллагаас 2025-2026 онд гүйцэтгэх санхүүгийн тайлангийн аудитаар баримтлах ерөнхий чиглэлд тусгагдсан болон бусад хууль тогтоомжтой холбоотой хэрэгжүүлсэн горим сорилын хүрээнд зөрчил илрээгүй болно.

4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тайлант хугацаанд www.shilendans.gov.mn цахим хуудсанд оруулбал зохих 171 мэдээллээс хугацаандаа оруулсан 164, хугацаа хоцроон байршуулсан 5, мэдээлэх хугацаа болоогүй 2 мэдээлэл байна.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн гэж дүгнэлээ.

4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Төрийн аудитын байгууллагаас 2025-2026 онд гүйцэтгэх санхүүгийн тайлангийн аудитаар баримтлах ерөнхий чиглэлд тусгагдсан болон бусад хууль тогтоомжтой холбоотой хэрэгжүүлсэн горим сорилын хүрээнд зөрчил илрээгүй болно.

Зүүнхангай сумын Ерөнхий боловсролын сургууль нь багшийн хөгжлийн зардлаас Багшийн мэргэжлийн хөгжлийн дэмжих сургалтын гэрээний үндсэн дээр төлбөрийг шилжүүлсэн. Гэвч гэрээний дагуу сургалтын хэрэгжилтийн явцад гэрээнд нэмэлт өөрчлөлт оруулснаар сургалтын зардлаас хэмнэлт үүсэн буцаж орсон 310.0 мянган төгрөгийг зарцуулах эрх нээхгүйгээр өөр харилцагч руу нэр данс зөрүүгээр чиглүүлэгч багшийн сургалтын төлбөрт буцаан орлого бууруулан шилжүүлсэн зөрчил илэрсэнд зөвлөмж өглөө.

4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

4.5.1 Завсрын аудитын талаар

Зүүнхангай сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2025 оны санхүүгийн тайланд завсрын аудит хийгээгүй болно.

4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Зүүнхангай сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2024 оны санхүүгийн тайлангийн аудитаар 735.5 мянган төгрөгийн 1 зөрчилд зөвлөмж өгснийг хэрэгжүүлэн ажиллаж, биелэлтийг 2025 оны 05 дугаар сарын 13-ны өдрийн 18 дугаар албан бичгээр Увс аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлж санхүүгийн тайлангийн аудитын fas.audit.mn систем бүртгэсэн байна.

Хүснэгт 4 Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

Үзүүлэлт	Өмнөх аудитын үзүүлэлт		Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Акт					
Албан шаардлага					
Зөвлөмж	1	735.5	1	735.5	100%
Нийт дүн	1	735.5	1	735.5	100%

/мянган төгрөгөөр/



4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дараагийн аудитаар анхаарах асуудал байхгүй байна.

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 155,683.5 мянган төгрөгийн алдаа, зөрчил илэрснээс 61,064.7 мянган төгрөгийн 2 алдааг залруулж, 2,808.8 зөрчилд зөвлөмж өгч, 91,809.9 мянган төгрөгийн 1 зөрчилд албан шаардлага өглөө.

Залруулсан алдаа:

1. Зүүнхангай сумын сургууль нь 2023 оны төсвийн жилийн дундуур үнэ тарифын нэмэгдэлтэй холбоотойгоор үүссэн түлш, халаалтын өр төлбөрийг тайлант онд Шүүхийн шийдвэрийн дагуу 46,769.8 мянга, 2025 оны түлш халаалтын өр төлбөрөөс 14,047.0 мянга, нийт 60,816.8 мянган төгрөгийг аймгийн Засаг даргын нэгдсэн данснаас төлснийг тайланд тусгаагүй орхигдуулсныг Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4 дэх заалтад “Үнэн зөв байх”, Иж бүрэн байх батламж мэдэгдлийг хангахгүй байсан тул залруулга хийлгэлээ.
2. Зүүнхангай сумын сургууль нь хувь хүний орлогын албан татварын 247.9 мянган төгрөгийг бүртгэлд тусгаагүй байсан нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.4 дэх хэсэгт “Нягтлан бодох бүртгэлд дараах зүйлсийг заавал бүртгэнэ”, 14.4.3 дахь “бүх өр төлбөр” Иж бүрэн байх батламж мэдэгдлийг хангахгүй байсан өглөгөөр бүртгүүлэн залруулга хийлээ.

5.2 Албан шаардлага

Илрүүлэлт:

Зүүнхангай сумын Ерөнхий боловсролын сургууль нь 91,809.9 мянган төгрөгийн дотуур байрны хоол, хүнсний материалыг худалдан авахдаа шууд худалдан авалт хийсэн байна.

Дээрх зөрчил нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.4 дэх хэсэгт “Захиалагч энэ хуулийн 10.8, 10.10-т заасан тохиолдолд энэ хуулийн 31.1.3, 31.1.4-т заасан аргаар тендер шалгаруулалтыг зохион байгуулж болно”, Засгийн газрын 2024 оны 02 дугаар тогтоолоор шинэчлэн баталсан “Шууд худалдан авч болох төсөвт өртгийн дээд хязгаар 20.0 сая төгрөг байна” гэж заасныг хэрэгжүүлэн ажиллаагүй нь Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Цаашид Засгийн газрын “Худалдан авах ажиллагаанд баримтлах төсөвт өртгийн дээд хязгаар тогтоох тухай” тогтоолыг хэрэгжүүлээгүй зөрчлийг давтан гаргахгүй байхаар албан шаардлага өглөө.

5.3 Зөвлөмж


Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Хууль тогтоомжийн хэрэгжилттэй холбоотой асуудал

1.1. Илрүүлэлт:

Зүүнхангай сумын Ерөнхий боловсролын сургууль нь багшийн хөгжлийн зардлаас Багшийн мэргэжлийн хөгжлийн дэмжих сургалтын гэрээний үндсэн дээр төлбөрийг шилжүүлсэн. Гэвч гэрээний дагуу сургалтын хэрэгжилтийн явцад гэрээнд нэмэлт өөрчлөлт оруулснаар сургалтын зардлаас хэмнэлт үүсэн буцаж орсон 310.0 мянган төгрөгийг зарцуулах эрх нээхгүйгээр өөр харилцагч руу нэр данс зөрүүгээр чиглүүлэгч багшийн сургалтын төлбөрт буцаан орлого бууруулан шилжүүлсэн байна.

Дээрх зөрчил нь Засгийн газрын 2023 оны 12 дугаар сарын 13-ны өдрийн 444 дүгээр тогтоолоор баталсан “Төрийн сангийн үйл ажиллагааны журам”-ын 3.4.21-д “Төсвийн



байгууллага орлогын хуулгыг өдөр тутам хянаж, тодорхой бус орлогын талаар нягталж, орлого бууруулах гүйлгээг гаргахдаа холбогдох нотлох баримт болон орлогын дэлгэрэнгүй хуулгыг төлбөрийн хүсэлтийн хамт хавсаргаж ажлын 3 өдрийн дотор төрийн санд мэдэгдэн залруулах хүсэлт гаргана”, 3.4.22-д “Бүртгэлийн данснаас дараах тохиолдолд зарцуулах эрх нээхгүй гүйлгээ хийхийг зөвшөөрнө”, 3.4.22.1-д “Улсын болон орон нутгийн төсвийн, нийгмийн даатгалын сангийн орлогын төвлөрүүлэлт, хуваарилалт”, 3.4.22.2-д “Татварын орлогын залруулга, буцаалт”, 3.4.22.3-д “Нийгмийн даатгалын сан, даатгалын компаниас тухайн даатгуулагчтай холбоотой даатгалын төлбөр”, 3.4.22.4-д Өрийн удирдлагын тухай хуулийн дагуу 32.6.1-д заасан зээлийн төлбөр”, 3.4.22.5-д “Барьцаа төлбөрийн буцаалт”, 3.4.22.6-д “Ялтны хөдөлмөрийн хөлс”, 3.4.22.7-д “Тендерийн орлогоос зөвхөн тендер зохион байгуулахтай холбоотой урсгал зардал (Худалдан авах ажиллагааны асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага, аймаг, нийслэл, дүүрэг дэх худалдан авах ажиллагааны нэгжид энэ хэсэг хамаарахгүй)”, 3.4.22.8-д “Төсвийн байгууллагын бүртгэлийн данс өөрчлөгдсөн, татан буугдсан тохиолдолд тухайн байгууллагын дансны үлдэгдэл”, 3.4.22.9-д “Төсвийн жилийн явцад Улсын Их Хурлаас соёрхон баталсан Засгийн газар хоорондын гэрээ болон олон улсын байгууллагаас авсан хөнгөлөлттэй зээл, дээд шатны төсвийн захирагчаас олгосон арга хэмжээний санхүүжилтийн зарцуулагдаагүй үлдэгдлийг санхүүжүүлсэн байгууллагад шилжүүлэх”, 3.4.22.10-д “Төсвийн байгууллагын үйл ажиллагааны давсан орлогыг санхүү, төсвийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүний шийдвэрийн дагуу нэмэлт төсвийн дансанд шилжүүлэх”, 3.4.22.11-д “Бэлтгэн нийлүүлэгчийн нэр, данс зөрснөөс буцсан гүйлгээ, картын гүйлгээний залруулга”, 3.4.22.12-д “Төрийн үйлчилгээний төлбөрийн буцаалт, залруулга” гэж заасныг хэрэгжүүлж ажиллаагүй нь Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

1.2. Өгсөн зөвлөмж:

Цаашид Засгийн газрын 2023 оны 12 дугаар сарын 13-ны өдрийн 444 дүгээр тогтоолоор баталсан “Төрийн сангийн үйл ажиллагааны журам”-ын 3.4.22 дахь хэсгийг хэрэгжүүлэн ажиллах.

2. Бүтэц, орон тоотой холбоотой асуудал

2.1. Илрүүлэлт:

Байгууллагын батлагдсан бүтэц, орон тоонд байхгүй жолоочийг слесарьд хавсруулж 2,498.8 мянган төгрөгийн нэмэгдэл цалин олгосон байна.

Дээрх зөрчил нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.3-д “Батлагдсан цалингийн сан, орон тооны хязгаарт багтаан төсвийн байгууллагын орон тоо, ажиллагчдын цалин хөлсийг тогтоох” гэж заасныг хэрэгжүүлж ажиллаагүй нь Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

1.2. Өгсөн зөвлөмж:

Цаашид Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.3-д “Батлагдсан цалингийн сан, орон тооны хязгаарт багтаан төсвийн байгууллагын орон тоо, ажиллагчдын цалин хөлсийг тогтоох” гэж заасныг дагаж мөрдөх.

Дээрх зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг аудитын тайланг хүлээн авснаас хойш 30 хоногийн дотор ирүүлж, биелэлтийг Увс аймаг дахь Төрийн аудитын газарт 2026 оны 05 дугаар сарын 05-ны өдрийн дотор, албан шаардлагын биелэлтийг 2026 оны 04 дугаар сарын 10-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

Байгууллагын нэр	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		/мянган төгрөгөөр/				Зөвлөмж	
							Үүнээс					
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Залруулсан		Залруулаагүй		Тоо	Дүн
							Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн



Зүүнхангай сумын ЕБ-ын сургууль	2	61,064.7	2	61,064.7			2	61,064.7				
Дүн	2	61,064.7	2	61,064.7			2	61,064.7				

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс									
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн
Бүтэц орон тоонд байхгүй хавсарсан олгосон байна.	1	2,498.8					1	2,498.8				
Дүн	1	2,498.8					1	2,498.8				

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/

Байгууллагын нэр	Нийт зөрчил		Үүнээс					
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил								
ЕБСургууль	1	310.0					1	310.0
Дүн	1	310.0					1	310.0
Худалдан авах ажиллагаатай холбоотой зөрчил								
Зүүнхангай сумын ЕБ-ын сургууль	1	91,809.9			1	91,809.9		
Дүн	1	91,809.9			1	91,809.9		
Нийт дүн	2	92,119.9			1	91,809.9	1	310.0

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

АУДИТЫН ТАЙЛАНГ

ХЯНАСАН:


ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР  М.БАТСУУРЬ/

АУДИТЫН МЕНЕЖЕР

М.БАТ-АМГАЛАН/


БЭЛТГЭСЭН:

АУДИТОР



9065555 15250/100 А/ П.ОЮУШ/

2026 оны 02 дугаар сарын 24-ний өдөр





УВС АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2026 оны 02 сарын 24 өдөр

Дугаар 01/17/А.2070457

Улаангом

УВА-2026/050/НА-СТА-ТЦЗ

Зөрчил давтан гаргахгүй байх тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд хийсэн Зүүнхангай сумын Ерөнхий боловсролын 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Зүүнхангай сумын Ерөнхий боловсролын сургууль нь 91,809.9 мянган төгрөгийн дотуур байрны хоол, хүнсний материалыг худалдан авахдаа шууд худалдан авалт хийсэн байна.

Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.4 дэх хэсэгт “Захиалагч энэ хуулийн 10.8, 10.10-т заасан тохиолдолд энэ хуулийн 31.1.3, 31.1.4-т заасан аргаар тендер шалгаруулалтыг зохион байгуулж болно”, Засгийн газрын 2024 оны 02 дугаар тогтоолоор шинэчлэн баталсан “Шууд худалдан авч болох төсөвт өртгийн дээд хязгаар 20.0 сая төгрөг байна” гэж заасныг тус тус хэрэгжүүлэн ажиллаагүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1 дэх хэсэгт “Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө”, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны 12 дугаар сарын 09-ний өдрийн А/95 дугаар тушаалаар баталсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам”-ын 4.2.1-д “Албан шаардлага өгөхөд дараах нийтлэг үндэслэлийг харгалзана”, 4.2.1.9-д “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль тогтоомж зөрчсөн нь энэ журмын 4.2.3-т заасан нөхцөл үүсээгүй бол”, 4.2.1.11-д “Хууль тогтоомж, гэрээ, хэлцэл зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал” гэж заасныг үндэслэн ШААРДАХ нь:

1. Засгийн газрын “Худалдан авах ажиллагаанд баримтлах төсөвт өртгийн дээд хязгаар тогтоох тухай” тогтоолыг хэрэгжүүлээгүй зөрчлийг давтан гаргахгүй байх, биелэлтийг 2026 оны 04 дүгээр сарын 10-ны өдрийн дотор Увс аймаг дахь Төрийн аудитын газар²-т ирүүлэх.

100



2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Зүүнхангай сумын Ерөнхий боловсролын сургуулийн захирал Ц.Баасандорж, нягтлан бодогч Э.Анхбаяр нарт даалгав.
3. Албан шаардлагыг хүлээн зөвшөөрөөгүй тохиолдолд Захиргааны ерөнхий хуулийн 92 дугаар зүйлийн 92.1 дэх хэсэгт заасны дагуу гомдол гаргах эрхтэй.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

АУДИТОР

ХЯНАСАН: АУДИТЫН МЕНЕЖЕР

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Р.АЮУШ

М.БАТ-АМГАЛАН

М.БАТСУУРЬ